



Вэбсайт: www.altanduulga.mn
Э-мэйл: info@altanduulga.mn



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН МАТЕРИАЛ 2024 он

**“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХК-ИЙН
2024 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДРИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ**

№	Танилцуулах асуудлын агуулга	Хугацаа	Хариуцах эзэн
1.	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бэлтгэл ажлын талаар танилцуулга	11:00-11:05	Хурал зохион байгуулах комиссын дарга Д.Дуламсүрэн Хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн 2024 оны 05 тоот тогтоолоор батлагдсан Хурлын дарга, Тооллогын комиссын бүрэлдэхүүний талаар танилцуулна.
2	Хуралд оролцогчдыг бүртгэх, “Ирцийн тухай” тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулах	11:05-11:20	Тооллогын Комисс Д.Гэрэлтуяа
3	Хурлыг нээх, хуралд оролцож байгаа ТУЗ-ийн гишүүд, Компанийн гүйцэтгэх удирдлага, ажилтнуудыг танилцуулах.	11:20-11:30	Хурлын дарга
4	Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, 2024 оны төсөв, төлөвлөгөө, зорилтын талаар танилцуулга	11:30-12:30	Гүйцэтгэх захирал Н. Одончимэг
5	Асуулт, хариулт	12.30-13:00	Асуултад ТУЗ-ийн дарга, Аудитын хорооны дарга, Гүйцэтгэх захирал хариулна.
6	Цайны завсарлага	13:00-13:30	
7	Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон	13:30-13:45	Д.Энхтогтох-ТУЗ-ийн гишүүн, Аудитын хорооны дарга

	санхүүгийн тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай		
8	Асуулт, хариулт	13:45 -14:00	
9	ТУЗ-ийн 2024 оны зардлын төсвийг танилцуулах.	14:00-14:10	Хурлын дарга
10	Асуулт, хариулт	14:10-14:15	Гүйцэтгэх захирал
11	ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын талаар	14:15-14:20	Хурлын дарга таницуулна \Хувьцаа эзэмшигчдийн 2018 оны 4 сарын 02-ны өдрийн “ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын тухай” 04 тоот тогтоолыг хэвээр мөрдөж ажиллана\
12	Асуулт, хариулт	14:20-14:25	
13	Ногдол ашиг хуваарилахгүй байх тухай ТУЗ-ийн 2024 оны 01 тоот тогтоолыг танилцуулах	14:25-14:30	Гүйцэтгэх захирал Ногдол ашиг хуваарилахгүй болсон үндэслэлээ танилцуулна.
14	Тооллогын комисс ажилдаа орж, хэлэлцэх асуудал бүрээр санал өгсөн дүнг танилцуулна.	14:30-15:00	Тооллогын комисс ажиллана. Аргачлал өгнө.
15	Хэлэлцсэн асуудлаар гарах тогтоолыг уншиж батлуулах	15:00-15:20	Хурлын дарга
16	Хурал хаах	15:20-15:30	Хурлын дарга



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Монгол улс, Хөвсгөл аймаг, Тариалан сум, Мандал баг
Хөвсгөл Алтандуулга ХК, Утас: 70386030, Факс: 70386031

Огноо 2024.03.05

№ 05

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал
зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59.4, 60.1, 60.2, 60.3, 60.4, 76.1.2 дахь заалтыг үндэслэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Хурлаас ТОГТООХ нь:

1. “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 11.00 цагт Хөвсгөл аймаг, Тариалан сум, Мандал багт байрлах “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн байранд хуралдуулсугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлсүгэй.

- Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, 2024 оны төсөв, төлөвлөгөө, зорилтын талаар танилцуулга
\\Танилцуулах нь: Н.Одончимэг - Компанийн Гүйцэтгэх захирал\\
- Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай
\\Танилцуулах нь: Д.Энхтогтох-ТУЗ-ийн гишүүн, Аудитын хорооны дарга\\
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг улируулан сонгох тухай
\\Танилцуулах нь: Д.Батхуяг- ТУЗ-ийн дарга\\
- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны зардлын төсвийг батлах тухай
\\Танилцуулах нь: Д.Батхуяг- ТУЗ-ийн дарга\\
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг тогтоох тухай
\\Танилцуулах нь: Д.Батхуяг- ТУЗ-ийн дарга\\
- “Ногдол ашиг хуваарилахгүй байх тухай” ТУЗ-ийн 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 01 дүгээр тогтоолын талаар
\\Танилцуулах нь: Д.Батхуяг- ТУЗ-ийн дарга\\

3. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн танилцах бичиг баримтын жагсаалт, хэлэлцэх асуудлаар санал өгөх “Саналын хуудас”-ны агуулгыг 1, 2 дугаар хавсралтаар баталсугай.

4. Компанийн тухай хуулийн 64.2, “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам батлах тухай” Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 дугаар тогтоолын 2.5-д заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох хувьцаа



эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 03 дүгээр сарын 25-ны өдрөөр тогтоосугай.

5. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах шийдвэр гарсантай холбогдуулан хурлын зарыг 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн дотор Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас, өөрийн компанийн цахим хуудсаар, 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдөр болон 03 дүгээр сарын 28-ны өдөр “Өдрийн сонин”, “Өнөөдөр” сониноор дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлсүгэй.

6. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэх баримт бичгийг бэлэн болгох эцсийн хугацааг 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрөөр тогтоосугай.

7. Хувьцаа эзэмшигч нь энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтад заасан бичиг баримтыг ажлын өдрүүдэд 10.00-17.00 цагийн хооронд Улаанбаатар хот, 8 дугаар хороо, 11 дүгээр хороолол, Ж.Батмөнхийн гудамж 39-2, “Велокс” оффисын 8 давхарт болон Хөвсгөл аймгийн Тариалан суманд байрлах компанийн байранд ирж танилцаж болохыг дурьдсугай.

8. Хувьцаа эзэмшигчдийн урьдчилж өгөх саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдрийг 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 11:00 цаг байхаар тогтсугай.

9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Д.Батхуягийг, хурал зохион байгуулах комиссын даргаар ТУЗ-ийн гишүүн, “Алтан хажир” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Д.Дуламсүрэнг томилсугай.

10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын даргаар Компанийн Хүний нөөцийн болон чанарын менежер Д.Гэрэлтуяа, гишүүдээр “Алтан хажир” ХХК-ийн нягтлан бодогч Б. Сарангарав, нярав Ш.Батцэнгэл нарыг тус тус томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА Д.БАТХУЯГ





“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн
ТУЗ-ийн 2024 оны 05 тоот
тогтоолын 01 дүгээр хавсралт

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

1. “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 05 тоот тогтоол
2. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан
3. Компанийн 2023 оны санхүүгийн тайлангийн талаарх хараат бус аудитын байгууллагын тайлан
4. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батлах тухай ХЭХ-ын тогтоолын төсөл №01
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг улируулан сонгох тухай ХЭХ-ын тогтоолын төсөл №02
6. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны зардлын төсвийг батлах тухай ХЭХ-ын тогтоолын төсөл №03
7. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын тухай ХЭХ-ын тогтоолын төсөл №04
8. “Ногдол ашиг хуваарилахгүй байх тухай” ТУЗ-ийн 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 01 тоот тогтоол
9. Компанийн 2024 оны зорилт болон үйлдвэрлэлийн төлөвлөгөө, зардлын төсвийн талаар
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх “Саналын хуудас”



“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн ТУЗ-ийн 2024 оны 05 сарын 02 тоот тогтоолын 02 дугаар хавсралт

“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХУВЬЦААТ КОМПАНИ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД ОРОЛЦОГЧДООС
САНАЛ АВАХ ХУУДАС

Хувьцаа эзэмшигчдийн овог нэр
Регистерийн дугаар.....
Санал өгөх хувьцааны тоо
Үйлчилсэн / Үнэт цаасны компани /

“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 11.00 цагт Хөвсгөл аймаг, Тариалан сум, Мандал баг, Хөвсгөл алтан дуулга ХК-ийн байранд болно.

№	Хэлэлцэх асуудал	Тухайн асуудлаар гарах шийдвэрийн төсөл	Зөвшөөрсөн	Түдгэлзсэн	Таггалсан	Таггалсан бол таны өгөх санал
1	Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай	Тогтоол №01				
2	ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгох тухай	Тогтоол №02				
3	ТУЗ-ийн 2024 оны зардлын төсвийг батлах тухай	Тогтоол №03				
4	ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын тухай	Тогтоол №04				

(Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэг + тэмдгийг бичнэ үү)

Хувьцаа эзэмшигч..... Гарын үсэг

2024 оны 04 дүгээр сарын-ны өдөр

Санал авах хуудсыг ашиглах санамж: Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр ирж хуралд оролцох боломжгүй бол 2024 оны 04-р сарын 17-ны 11.00 цагаас өмнө “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн УБ хот болон орон нутгийн байранд очиж, хурлын материалтай танилцан санал авах хуудсаар саналаа өгнө. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол тухайн хүндээ итгэмжлэл өгч нотариатаар батлагаажуулсан байна. Засварласан болон балласан санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.

“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 11.00 цагт Хөвсгөл аймаг, Тариалан сум, Мандал баг, “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн байранд болно.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөр тогтоосон болно.

Хурлаар хэлэлцэх асуудал:

- Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, 2024 оны төсөв, төлөвлөгөө, зорилтын талаар танилцуулга
- Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг улируулан сонгох тухай
- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны зардлын төсвийг батлах тухай
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг тогтоох тухай
- “Ногдол ашиг хуваарилахгүй байх тухай” ТУЗ-ийн 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 01 дүгээр тогтоолыг танилцуулах

Хурлын материалтай www.altanduulga.mn цахим хуудаснаас болон ажлын өдрүүдэд 10⁰⁰-17⁰⁰ цагийн хооронд Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 8 дугаар хороо, 11 дүгээр хороолол, Ж.Батмөнхийн гудамж 39-2, “Велокс” оффисын 8 давхарт болон Хөвсгөл аймгийн Тариалан суманд байрлах компанийн байранд ирж танилцах боломжтой.

Хувьцаа эзэмшигч та өөрийн биеэр хуралд оролцох боломжгүй бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж нотариатаар баталгаажуулсан байна. Саналын хуудсаар урьдчилж саналаа өгөх бол УБ хот болон орон нутаг дахь компанийн байранд ирж 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 11.00 цагаас өмнө өгнө.

Холбоо барих утас: Хурал зохион байгуулах комиссын дарга Д.Дуламсүрэн утас: 99119138, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга С.Оюунгэрэл утас: 99165186, цахим шуудангийн хаяг: info@altanduulga.mn.

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС


КОМПАНИЙ 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ТУЗ-ИЙН ГАРГАСАН ДҮГНЭЛТ

2023 онд байгууллагын бүх түвшинд: а) Хүний нөөцийг чадавхижуулах, давтан сургах, б) Шинэчилэн сайжруулсан тоног төхөөрөмж, үйлдвэрлэлийн технологийн үе шатны найдвартай ажиллагааг хангах тал дээр хүний хүчин зүйлийн оролцоог илүү чанаржуулах, с) Ажлын байрны аюулгүй, эрүүл орчинг жилээс жилд үе шаттай сайжруулж буй зорилгынхоо хүрээнд бодит үр дүн гаргаж ажилласан байна.

Энэ онд “Магадлан итгэмжлэх лаборатори”-ийг өргөжүүлэн ашиглалтад бүрэн оруулсан нь газар тариалан, боловсруулах үйлдвэрлэлийн шат дамжлага бүрт чанар, стандартыг мөрдөх, хянах, зэрэгцүүлсэн дүгнэлт хийх зэрэг олон талын ач холбогдолтой чухал хөрөнгө оруулалт болжээ.

Боловсруулах үйлдвэр, газар тариалан, аж ахуйн чиглэлээр төлөвлөсөн ажлуудаа дотоод нөөц боломж, хөрөнгө санхүүгийн чадамждаа тулгуурлан үе шаттай гүйцэтгэсэн талаар гүйцэтгэх удирдлагын тайлангаас танилцлаа. Орон нутагтаа газар тариалан, боловсруулах үйлдвэрийн технологио байнга шинэчилэн сайжруулж, хэрэглэгчдийг хэрэгцээт бүтээгдхүүнээр нь тасралтгүй хангаж ажилласан байна.

Үйл ажиллагаа болон санхүүгийн гол үзүүлэлтүүдийг графикт зэрэгцүүлэв.



2023 онд “газар тариалан, гурилын үйлдвэрлэл” менежментийн хувьд тусдаа ажилласан хэдий ч хөрөнгө оруулалт санхүүжилт татах зорилгоор банк санхүү, төрийн болон төслийн байгууллагуудад хандахад “хамаарал” хэвээр байж, хөнгөлөлттэй урт хугацаат зээл хөтөлбөрт хамрагдаж чадсангүй. Энэ салбарт урт хугацаатай, өртөг багатай зээл, хөрөнгө оруулалтын эх үүсвэр тун чухал.

Алтан дуулга ХК-ийн хувьд 2023 онд өглөг авлага барагдуулах тал дээр сайн ажиллаж, алдагдлыг 70 %-иар бууруулсан байна.

Алтан хажир ХХК-ийг шинэчилэн зохион байгуулж, газар тариалан эрхлэлтийг дэмжсэн аливаа хөтөлбөр, гадаад дотоодын болон Засгийн газрын бодлогын чанартай хөтөлбөрт хамруулах зэргээр өрсөлдөх чадварыг сайжруулж, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн үнэ цэнийг нэмэгдүүлэх талаар дахин нэг алхам хийх нь зүйтэй юм байна.

Бүтэц, зохион байгуулалтын талаар судалгаа тооцоотой саналыг хөрөнгийн биржид бүртгэлтэй, тэргүүлэх компаниудын туршлага, түүхээс “компанид ашигтай бүтэц-загвар”-ыг гарган холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд хэрэгжүүлэх асуудлыг энэ удаа нээлттэй ярилцаж шийдвэрлэхийг зөвлөж байна.

2023 онд компанийн үйл ажиллагааг дараахь хоёр чиглэлээр дүгнэв. Үүнд:

Тоон үзүүлэлтийн хувьд: “.....”

Тоон бус үзүүлэлтийн хувьд: “.....”

Нэгдсэн дүгнэлт: “.....” гэж дүгнэв.

2024 оны сарын

**“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр

№ 01

Тариалан сум

**Компанийн жилийн үйл ажиллагааны
болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн
гаргасан дүгнэлтийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 76.1.11 дэх заалт, “Хөвсгөл алтан дуулга” хувьцаат компанийн дүрмийн 7.8.3 дахь заалтыг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

1. “Хөвсгөл алтан дуулга” хувьцаат компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг хавсралтаар баталсугай.

2. Тус компанийн 2023 оны үйл ажиллагааг “.....” гэж дүгнэхийн зэрэгцээ Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтэд гарсан санал, өгөгдсөн үүргийг хэрэгжүүлж ажиллахыг Компанийн удирдлагуудад даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Хөвсгөл Алтандуулга ХК

ТУЗ-ийн зардлын төсөвийн гүйцэтгэлийн тайлан 2023 он

Нэгжийн нэр

ТУЗ

Нэгжийн код

005-1

Зардлын ангилал	Төсөв	Гүйцэтгэл	эзлэх %	Зөрүү
Үйл ажиллагааны зардал				
Цалин хөлсний зардал	37,560,000.00	37,354,380.95	45.44	205,619.05
Гишүүдийн урамшуулал	13,410,000.00	6,016,000.00	7.32	7,394,000.00
Нийгмийн даатгалын шимтгэлийн зардал	6,100,000.00	5,042,841.00	6.13	1,057,159.00
Шуудан холбооны зардал	1,320,000.00	1,320,000.00	1.61	0.00
Бичиг хэргийн зардал	400,000.00	50,000.00	0.06	350,000.00
Шатахууны зардал	19,200,000.00	15,220,019.49	18.52	3,979,980.51
Зар сурталчилгаа	600,000.00	800,000.00	0.97	-200,000.00
Хурлын зардал	2,400,000.00	30,000.00	0.04	2,370,000.00
Ажлын албаны болон бусад	9,000,000.00	4,970,950.00	6.05	4,029,050.00
Үйл ажиллагааны нийт зардал	89,990,000.00	82,200,909.95	100.00	7,789,090.05

“ Хөвсгөл Алтандуулга “ ХК-ийн ТУЗ-ийн 2024 оны зардлын төсөв

д/д	Зардлын төсөв	Сарын зардал		Сар	Нийт зардал /төг
1	ТУЗ-ийн дарга	2,500,000	1	12	30,000,000
	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	693,000	1	12	8,316,000
	ТУЗ-ийн гишүүдийн цалин, нэмэгдэл : Энгийн гишүүд	50,000	6	12	3,600,000
	Хараат бус гишүүд	70,000	3	12	2,520,000
	Хороодын даргын нэмэгдэл	30,000	3	12	1,080,000
	ТУЗ-ийн даргын нэмэгдэл	30,000	1	12	360,000
	Дүн	3,373,000			45,876,000
2	НДШ	455,355			6,193,260
Цалин хөлс,урамшуулал, ндш зардал		3,828,355			52,069,260
3	Хуралд оролцсон байдлыг харгалзан олгох нэмэгдэл	50,000	141		7,037,000
4	Шуудан холбооны зардал	110,000	12		1,320,000
5	Бичиг хэргийн зардал	70,935	4		283,740
6	Цайны зардал	35,000	4		140,000
7	Томилолтын зардал	350,000	6		2,100,000
8	Шатахуун	1,300,000	12		15,600,000
9	Хурлын зар	800,000	1		800,000
10	Ажлын албаны болон бусад	1,050,000	4		4,200,000
	Дүн	7,594,290.00			83,550,000.00

**“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр

№ 03

Тариалан сум

**Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны
зардлын төсвийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62.1.12, 65.6.6 дахь заалтыг үндэслэн “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

1.Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны зардлын төсвийг 83,550,000 \ Наян гурван сая таван зуун тавин мянга\ төгрөгөөр баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

**“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр

№ 04

Тариалан сум

**ТУЗ-ийн гишүүдийн цалин
урамшууллын тухай**

Компанийн тухай хуулийн 62.1.13 дахь заалт, “Хөвсгөл алтан дуулга” Хувьцаат Компанийн дүрмийн 7.8.7, 7.44-д заасныг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

1. Тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн 2024 оны цалин, урамшуулал, нэмэгдэл болон Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн хурал, хороодын хуралд оролцсон оролцооны нэмэгдлийг Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2018 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай” 04 дүгээр тогтоолын дагуу олгож байхаар тогтсугай.

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тогтмол цалин, урамшуулал, нэмэгдлийг жилийн эцэст, оролцооны нэмэгдлийг тухай бүр олгож байхыг ерөнхий нягтлан бодогч Ж.Отгоннямд зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА

**“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХК-ИЙН ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН ЦАЛИН,
УРАМШУУЛЛЫН ТУХАЙ**

“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн үйл ажиллагаа, санаачлагыг идэвхжүүлэх, аливаа асуудалд ажил хэрэг, бүтээлчээр хандах хандлагыг дээшлүүлж, хариуцлагыг нэмэгдүүлэх, зохион байгуулсан ажилд оролцсон оролцоо, ажлын үр дүнг үнэлж, урамшуулах зорилгоор Компанийн тухай хуулийн 62.1.13 дахь заалт, ХК-ийн дүрмийн 7.8.7, 7.44 дэх заалтын дагуу тэдэнд цалин, урамшуулал, нэмэгдэл болон Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн хурал, хороодын хуралд оролцсон оролцоог харгалзан тодорхой нэмэгдэл олгож байхаар 2018 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр хуралдсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас 04 тоот тогтоол гарган хэрэгжүүлж байгаа юм. Дээрх тогтоолоор:

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН
ЦАЛИН, УРАМШУУЛАЛ, НЭМЭГДЛИЙН ХЭМЖЭЭ**

ТУЗ-ийн гишүүдийн цалин, нэмэгдэл		Хэмжээ, холбогдох татвар шимтгэлийг суутгасан байдлаар /төг/
Сард олгох тогтмол цалин нэмэгдэл	Энгийн гишүүд	50,000
	Хараат бус гишүүд	70,000
	Хороодын даргын нэмэгдэл	30,000
	ТУЗ-ийн даргын нэмэгдэл	30,000
Оролцоонд үндэслэсэн нэмэгдэл	Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн хурал, ТУЗ-ийн дэргэдэх хороодын хуралд оролцсон тоогоор	50,000

байхаар тогтоосон юм.

2023 онд ТУЗ-ийн гишүүдийн урамшуулалд 7 560 000 төгрөг зарцуулсан байна. 2024 оны хувьд Хувьцаа эзэмшигчдийн хурлаас өмнө нь гаргасан шийдвэрийг хэвээр үргэлжлүүлэн мөрдөх саналтай байна. Иймд ХЭХ-аас гарах тогтоолын төслийг танилцуулж байна. Та бүхэн энэхүү тогтоолыг баталж өгнө үү?

**“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр

№ 02

Тариалан сум

**Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг
улируулан сонгох тухай**

Компанийн тухай хуулийн 77.2 дахь заалтыг үндэслэн “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

1.Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн Д.Батхуяг, З.Батсүх, Д.Дуламсүрэн, М.Зулзаяа, Ц.Наран-Учрал, О.Тунгалаг, хараат бус гишүүн Л.Даваа, Т. Мөнхгэрэл, Д.Энхтогтох нарыг улируулан сонгосугай.

ХУРЛЫН ДАРГА



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Монгол улс, Хөвсгөл аймаг, Тариалан сум, Мандал баг
Хөвсгөл Алтандуулга ХК, Утас: 70386030, Факс: 70386031

Огноо 2023.02.16

№ 01

Ногдол ашиг хуваарилахгүй байх тухай.

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5, 46.6, 80 дугаар зүйлийн 80.2, 80.4 дэх хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээс өгсөн эчнээ санал хураалтын дүнг үндэслэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас ТОГТООХ нь.

1. “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн 2022 оны санхүүгийн урьдчилсан тайланг харгалзан Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсүгэй.

2. Ногдол ашиг хуваарилахгүй болсон үндэслэл, энэхүү тогтоолыг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахаар тогтсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.БАТХУЯГ



Хөвсгөл Алтандуулга ХК-ний ТУЗ болон гишүүдэд

Ногдол ашиг тараахгүй байх үндэслэл, тайлбар

Хөвсгөл Алтандуулга ХК нь өмнөх онуудад баримталж байсан дундын зуучлалгүйгээр хэрэглэгчидэд чанартай бүтээгдэхүүн нийлүүлэх, зах зээл дэх хамгийн хямд үнийг санал болгох бодлогыг үргэлжилүүлэн хэрэгжүүлэхийн зэрэгцээ зардалыг багасгах, үр ашигтай ажиллахыг зорин ажилласанаар борлуулалтын орлогыг 3.7хувиар нэмэгдүүлж, өртөгийг 4.3 хувиар, удирдлага, борлуулалтын зардалыг 6.7 хувиар тус тус бууруулсан байна.

2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар -285,3 сая төгрөгийн алдагдалтай ажилласан нь өмнөх онтой харьцуулахад алдагдалыг 3.3 дахин бууруулсан байгаа ба санхүүгийн тоон мэдээлэл, бүртгэл үнэн зөв хийгдсэн болон санхүүгийн алдагдал бодит болохыг баталгаажуулахаар хөндлөнгийн аудит ажиллаж байна.

2023 оны жилийн эцсийн орлого үр дүнгийн тайланг хураангуй байдлаар, өмнөх онтой харьцуулсан байдлаар харуулвал.

	/сая төгрөгөөр/	
	2022 он	2023 он
Борлуулалтын орлого	9,997.9	10,368.9
Борлуулалтын өртөг	9,193.7	8,802.3
Борлуулалтын ашиг	804.1	1,566.5
Бусад орлого	550.4	520.1
Ерөнхий удирдлагын зардал	833.5	777.9
Борлуулалтын зардал	682.6	510.4
Санхүүгийн зардал	578.6	938.7
Бусад зардал	36.9	16.5
Валютын ханшийн ашиг/алдагдал	7.1	74.0
Татварын зардал	6.0	3.3
Татварын дараах цэвэр ашиг/алдагдал	-790.2	-234.3

Хэдийгээр орлогыг нэмэгдүүлж, зардалуудыг тодорхой хувиар бууруулсан ч өмнөх онуудад дурдаж байсан хүчин зүйлүүдийн нөлөөлөлөөр үүсээд байгаа мөнгөн хөрөнгийн дутагдалд орсон хэвээр байна.

Мөнгөн хөрөнгийн дутугдалыг хангах, зах зээлээ алдахгүйн тулд үйл ажиллагааг тогтвортой явуулах зорилгоор ББСБ-аас богино хугацааны, бага хэмжээний зээлийг тухай бүр нь авах / банкны зээл хугацаа хэтэрсэнээс үүдэлтэй арилжааны зээл авах боломжгүй болсон/, ОХУ-аас таваарын улаанбуудай импортлох, ХААДС-аас мөнгөн хөрөнгөд тааруулан таваарын улаанбуудай худалдан авах, тариаланч бэлтгэн нийлүүлэгчийн төлбөрийг бага багаар хэсэгчилэн төлөх зэрэг арга хэмжээг шат дааалан авч ажилласан хэдий ч,

- ББСБ-аас авсан богино хугацааны зээл өндөр хүүтэй,
- Төрийн банкнаас авсан хөнгөлөлтэй зээлийн хугацаа дууссан ба төлөлт хийгдээгүйгээс үүдэн гэрээний дагуу арилжааны банкны хүү бодогдож эхэлсэн,

- Төрийн банкнаас авсан арилжааны болон хөнгөлөлттэй зээлийн хугацаа хэтэрсэнээс нэмэгдүүлсэн хүү тооцож эхэлсэн,
- ОХУ-аас авсан импортын буудайн төлбөр дайнтай холбоотойгоор ОХУ руу шилжүүлэх рублийн шилжүүлэгийг арилжааны банкууд хязгаарласанаар ББСБ-аар дамжуулан төлбөрийн шилжүүлэг хийгдэж байгаа нь ханшийн өндөр зөрүү үүсгэж байгаа /мөнгөн хөрөнгийн дутагдалаас үүдэн ОХУ руу шилжүүлэх төлбөрийг их дүнгээр хийх боломжгүй байгаа тул цувуулан бага хэмжээгээр төлж байгаа нь шимтгэлийн зардалыг нэмэгдүүлж байгаа юм/
- Мөнгөн хөрөнгийн дутагдалаас үүдэн санхүүгийн боломжинд тулгуурлан тариалалт хийсэн нь га-аас авах ургацын нэгжийн өртөгийг нэмэгдүүлсэнээс газар тариалангаас олох ашгийг бууруулсан зэрэг томоохон шалтгаануудын улмаас энэ онд алдагдалтай гарч байна.

Иймээс 2023 онд ногдол ашиг хуваарилах боломжгүй байгааг компанийн ТУЗ болон гишүүдэд танилцуулж байна.



**ХӨВСГӨЛ
АЛТАНДУУЛГА**
Хувьцаат компани

Сайн сайхны төлөө бүтээв!



2023

Үйл ажиллагааны тайлан

“Хөвсгөл Алтандуулга” ХК

Улсын бүртгэлийн дугаар	1710001001
Регистрийн дугаар	2034565
Үүсгэн байгуулагдсан огноо	1996.04.25
Үйл ажиллагааны чиглэл	Үр тариа үйлдвэрлэл
	Гурил үйлдвэрлэл
	Малын тэжээлийн үйлдвэрлэл
	Хүнсний ногоо тариалах
	Гадаад дотоод худалдаа
	Малын аж ахуй
	Хууль тогтоомжоор хориглоогүй бусад төрлийн үйл ажиллагаа
Хувь нийлүүлсэн хөрөнгө	157,342 мянган төгрөг
Компанийн хаяг	Хөвсгөл, Тариалан, Мандал
Холбоо барих утас	70386030, 70386055, 77116031
Хувьцаа эзэмшигчдийн тоо	489 хувьцаа эзэмшигчидтэй (2023.12.31 байдлаар)



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

2023 оны 03 дугаар сарын 15-ны өдөр хуралдсан компанийн ТУЗ-ийн хурлаас Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах шийдвэр гаргасан ба хувьцаа эзэмшигчдийн хурлын даргаар ТУЗ-ийн дарга Д.Батхуягийг, Тооллогын комиссын даргаар Б.Юмжирдулам, гишүүдээр Ш.Батцэнгэл, Д.Гэрэлтуяа нарыг томилсон байна.

Мөн Хувьцаа эзэмшигчдийн хурал удирдах даргаар томилогдсон Д.Батхуяг хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хуралд оролцох боломжгүй байгааг харгалзан Хурлын даргаар ТУЗ-ийн гишүүн Д.Дуламсүрэнг томилсон ТУЗ-ийн 4 дүгээр сарын 25-ны өдрийн 07 дугаар тогтоол гарсан байна.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр Тариалан суманд боллоо. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөс 2023 оны 4 сарын 4-ний өдрөөр тасалбар болгон авсан бүртгэлээр тус компанийн нийт хувьцаа эзэмшигч: 496, Хувьцааны тоо : 15 734 200 байв. Үүнээс “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн халаасны хувьцаа болох 783,545 ширхэг хувьцааг хасаад нийт санал өгөх эрхтэй хувьцаа 14 950 655 ширхэг, хувьцаа эзэмшигч нь 495 байлаа. \

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд 8,578,325 ширхэг энгийн хувьцаа эзэмшиж буй 10 хувьцаа эзэмшигч оролцож, 1,922,116 ширхэг энгийн хувьцаа эзэмшиж байгаа 11 хувьцаа эзэмшигч урьдчилан саналаа ирүүлснээр нийт саналын эрх бүхий 14 950 655 ширхэг энгийн хувьцаанаас 10,500,441 ширхэг буюу хувьцаа эзэмшигчдийн 70,2 хувь нь оролцлоо.

Тус хурлаар:

- Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, 2023 оны төсөв, төлөвлөгөө, зорилтын талаар танилцуулга
- Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай
- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны зардлын төсвийг батлах тухай
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг тогтоох тухай асуудлуудыг хэлэлцэн шийдвэр гаргалаа.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын бэлтгэл ажлыг хангаж, хурлын зарыг холбогдох хууль, СЗХ-ноос гаргасан журмын дагуу өдөр тутмын сонин, өөрийн болон МХБ-ийн цахим хуудсаар мэдээлж, танилцах материалыг өөрийн цахим хуудсаар болон Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоогоор дамжуулан үнэт цаасны комданиудад хүргүүлэн ажиллалаа. Хувьцаа эзэмшигчдийн хурлын материалыг хуулийн хугацаанд нв эрх бүхий байгууллагад хүргүүлэв.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

Хөвсгөл алтан дуулга ХК-ийн гүйцэтгэх захирлаас 2023 онд Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах санхүү, эдийн засгийн боломж үүсээгүй байгаа, нээ асуудалтай холбогдуулан тодорхой үндэслэл, тайлбарыг ТУЗ-ийн гишүүдэд ирүүлсний дагуу “Ногдол ашиг хуваарилахгүй байх тухай” ТУЗ-ийн 01 тоот тогтоолыг эчнээ санал хураалтаар гаргав.

2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Компанийн гүйцэтгэх захирлын сонсголыг ТУЗ-ийн хурлаар хэлэлцэв.

2024 оны үйлдвэрлэлийн төлөвлөгөө, зорилт, зардлын төсвийг баталсан ТУЗ-ийн тогтоол гаргав.

Компанийн засаглалын шинээр батлагдсан кодексийн зарчимд нийцүүлэн Төлөөлөн удирдах зөвлөлийн хороод, түүний бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж батлав. Мөн “Залгамж халааны бодлогын баримт бичиг”-ийг ТУЗ -өөс гаргав.

Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримталж байгаа бодлогыг хэрэгжүүлэн, газар тариалангийн үйлдвэрлэлээ өргөжүүлэх, усалгаатай газар тариалан эрхлэх, хөрс хамгаалах, нөхөн сэргээх ажлыг үе шаттай гүйцэтгэх, нэгж талбайгаас авах ургацын хэмжээг нэмэгдүүлэн, бүтээгдэхүүний тоо, чанарыг дээшлүүлэн улмаар компанийн эдийн засаг, хөрөнгө санхүүгийн чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 63 дугаар тогтоолын дагуу Хүнс болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр олгож байгаа хөнгөлөлттэй зээл авах асуудлыг дэмжиж ТУЗ-өөс тогтоол гаргасан.

Гэвч энэхүү зээлд хамрагдаж чадаагүй болно.

Цалинг өөрчлөн тогтоох, чөлөө олгох гэх зэрэг асуудлыг ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн холбогдох шийдвэрийг гаргав.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд ТУЗ-ийн дарга хаврын тариалалтын бэлтгэл ажил, ургац хураалтын үеэр орон нутагт байнга ажиллаж, холбогдох үүрэг даалгаврыг цаг тухай бүрт нь өгч ажиллав.





ГАЗАР ТАРИАЛАН

2023 онд Алтан Хажир ХХК нь үйл ажиллагаагаа хэвийн, тогтвортойгоор үргэлжлүүлэн явуулахад зорьж, төлөвлөн өөрсдийн санхүүгийн боломжид тулгуурлан үйлдвэрлэлээ явууллаа.

Энэ онд нийт 2466,6 га талбайд улаанбуудайны 4 сорт, овъёос, халтар арвай, рапс, ногоон тэжээлийн таримлуудыг тариалсан.



Таримлын төрөл	Тариалал т /га/	Ургац /тн/
Улаанбуудай	2,167	2,469.0
Тосны ургамал	114	61.0
Халтар арвай	23	11.3
Овьёос	67	182.6
Тэжээлийн ургамал	94	250.0
Нийт	2,465	

Энэ оны тариалалтын онцлог нь Эрт тарих, Тоонолжлон тарих Уламжлалт тарилтын гэсэн 3 өөр төрлийн агротехнологийг баримталж тариалсанд оршино.

Ургамал хамгааллын бодис сонгохдоо тухайн талбайд тархсан хог ургамлын төрөл зүйлийг тодорхойлж тэдгээр ургамалд үйлчлэх сонгомол үйлчилгээтэй бодисыг тухайн бодисыг дагаж ирсэн заавар тун нормын дагуу цацсан ба бүх талбайд органик шингэн бордоо болох шимт бор бордоог 2 удаагийн давтамжтай ургамал хамгааллын үйл ажиллагааг нийт 4666,3 га талбайд хийсэн.

2021 оноос эргэлтийн талбайг бусад тариаланчдад түрээслэх ажлыг эхлүүлээд байгаа ба 2022,2023 онуудад мөн энэхүү ажлыг үргэлжүүлэн ажиллав.

Уриншийг 779,2 га уринш хийхээр төлөвлөсөн ба Төлөвлөгөөний дагуу 2023 оны 07 сарын 02-06-ны өдрүүдэд уринш хийж дууссан.

Өмнөх жилүүдийн адилаар туршилтын тариалалтууд хийгдсээр мэдээллийн санг бүрдүүлсээр байна.

ҮТРЭМИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ


- ✓ Боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаанд нийцүүлэн нийт 5153,9 тн будааг цэвэрлэв.
- ✓ Хаврын тариалалтын үед 429,5 тн үр ариутгаж, 46,7 тн үр бордож, 90.6 тн цэвэр үрийг зах зээлд нийлүүлсэн.
- ✓ Аж ахуй нэгж болон хувь хүнээс худалдан авсан 1001820 тн будааг ангилан буулгаж, цэвэрлэх, ялгах ажлыг гүйцэтгэсэн.
- ✓ Намрын тариа хураалтаас хойш нийт 240 тн будааг няцалж тэжээлийн будаа болгон зах зээлд нийлүүлсэн.
- ✓ Халтар арвай хуурч, халтар арвайн гурил болгон зах зээлд нийлүүлэх ажлыг өдөр тутам хийж байна.



ГУРИЛ ҮЙЛДВЭРЛЭЛ

- 2023 онд 4.7 мян тн улаанбуудай тээрэмдсэнээс 78% буюу 3.7 мян.тн гурил, 22% буюу 1,1мян.тн тэжээлийн хивэг үйлдвэрлэсэн байна.
- Энэ онд ОХУ-аас 1518тн таваарын улаанбуудай импортолж, ХААДС-аас 1186,4тн таваарын улаанбуудай худалдан авч үйлдвэрлэлд нийлүүлсэн.



Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, 5-н жилийн харьцуулалт



- Энэ жил хуучин тэжээлийн үйлдвэрийн тоног төхөөрөмжинд тулгуурлан, ургацын цавуулагийн чанар муу байсанаас үүссэн ГҮ-т тэнцэхгүй улаанбуудайг бяцлан малчидад нийлүүлж эхэллээ.



БГ-085 савлагааны хэмжээгээр



Тоног төхөөрөмжийн урсгал засвар:

Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн ээлжит засвар, барилгын дээврийн засварын ажлыг хийлээ.

- ✓ Силос болон үтрэм, агуулах, боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтлийг ерөнхий механиктай хамтран тогтоож, ээлж, засварыг тухай бүрд нь хийж гүйцэтгэв.
- ✓ Боловсруулах үйлдвэрийн 40 булыг БНХАУ-аас захиалж, солин тохиргоо хийсэн.




Сайн сайхны төлөө бүтээв!



БОРЛУУЛАЛТ МАРКЕТИНГ

- Өөрийгөө санхүүжүүлэх эхлэлийг тавин ажиллах
 - Сүүлийн 2 жилийн ургацын чанарын байдлаас үүдэн нэрийн дэлгүүрийн борлуулалтыг 4,000 тн-с буулгахгүй байх зорилтыг тавин ажиллах
- гэсэн 2 үндсэн зорилт тавин ажилласан

2023 он түүхий эдийн хомсдол, чанараас үүдэлтэй гурилын борлуулалтын огцом уналттай жил болов.



Борлуулалтын алба нь Мөрөн, Тариалан, Улаанбаатар гэсэн 3 сувагт хуваан ажиллав. 2023 оны хувьд жижиглэнгийн худалдан авалт өмнөх жилүүдтэй харьцуулахад харьцангуй бага байсан бол сумын дэлгүүр болон ченжүүдийн борлуулалт огцом буурсан байна.



Гурилын борлуулалтанд үүссэн хүндрэлтэй нөхцөл байдлаас шалтгаалан бид Алтан Хажир ХХК тай хамтран малын тэжээлийн борлуулалтад онцгой анхааран ажилласнаар эерэг үр дүнг гаргасан.

Үүнд:

- ГҮ болон стандартад тэнцээгүй буудайг бяцлаж борлуулалтад шинээр нэвтрүүлсэн.
- Тариаланчдаас стандарт бус буудайг худалдан авах үйл ажиллагааг эхлүүлсэн.
- Мөрөн сумын тэжээлийн зах зээлд өөрийн байр суурийг олох, цаашид зах зээлийг бүрэн хангах эхний алхмыг амжилттай хийж чадсан.

ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ

- ✓ Дотоод хяналтын лабораториос магадлан итгэмжлэгдсэн лаборатори болж өргөжсөнтэй холбогдуулан “Лабораторийн чанарын гарын авлага” боловсруулж, түүнийг дагасан 24 журам батлуулан мөрдөж байна.
- ✓ Хими болон ургамал, хорио цээрийн 2 дэд лабораторитой болж үйл ажиллагаа шинжилгээний цар хүрээг нэмэгдүүлсэн.
- ✓ Магадлан итгэмжлэлийн хүрээнд ургамал, хорио цээрийн лабораторид нийт 3 бүтээгдэхүүнд 22 үзүүлэлтэд шинжилгээ, химийн лабораторид 3 бүтээгдэхүүнд 19 үзүүлэлтийн дагуу шинжилгээ хийж байна.



- ✓ Ургац хураалтын үед нийт 221 дээжид үр тарианы чанар, хорио цээрийн шинжилгээ хийсэн. Үүнээс 72 дээж нь төлбөртэй шинжилгээ байв.
- ✓ ХАБҮЛЛ-ын Стратеги төлөвлөлт, эрсдлийн үнэлгээний төвийн ур чадварын сорилтод 214 дугаартай хөтөлбөрт ургамал хорио цээрийн чиглэлээр “Үрийн хошуу буудайн соёлолт, ургах эрчим тодорхойлох” үзүүлэлтээр амжилттай хамрагдаж 23-ХЦ16 кодтой гэрчилгээ авсан.
- ✓ Хөвсгөл болон Булган аймгийн СХЗХэлтсийн лабораторитой үр тариа, гурил, ундны ус зэрэг үзүүлэлтээр харьцуулсан шинжилгээнд хамрагдсан.



- ✓ Лабораторийн үйл ажиллагаа нь чанарын тогтолцооны шаардлагад нийцэж буйг тодорхойлох зорилгоор дотоод аудитыг дэд лаборатори тус бүрд 2 удаа хийсэн.



ХАМТЫН АЖИЛЛАГАА, ТӨСӨЛ

Хэрэгжүүлсэн төсөл:

- ✓ Ургамал хамгааллын бодис, эрдэс бордоо импортлох төслийг амжилттай хэрэгжүүлж, 11 төрлийн 4586 тн бордоог импортлох 5 жилийн хугацаатай тусгай зөвшөөрөл авсан.
- ✓ Дотоод хяналтын лабораторийн үйл ажиллагааг өргөжүүлж магадлан итгэмжлүүлэх төслийг амжилттай хэрэгжүүлэн 2023 оны 4 дүгээр сард анхан шатны үнэлгээнд орж 2023.09 сард 2 жилийн хугацаатай итгэмжлэгдсэн.



Гадаад хамтын ажиллагаа:

